

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер
шалгаруулалтын
нэр:

Багахангайн үйлдвэрлэл технологийн паркийн хүнд
үйлдвэрлэлийн бүсийн хөгжлийн төлөвлөгөө (Улаанбаатар
хот)

Тендер
шалгаруулалтын
дугаар:

НХААГ/ 20250203692

[2025 он]

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- | | |
|--|---|
| 1. Тендерийн цар хүрээ | <ul style="list-style-type: none">1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон үйлчилгээ (цаашид “үйлчилгээ” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна.1.2. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.1.3. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.1.4. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана.1.5. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол хуулийн 11.9-д зааснаар ажлын үр дүнд бий болох оюуны өмчийн эрхийг захиалагч, түүний нэр заасан этгээд эзэмшинэ. |
| 2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг | <ul style="list-style-type: none">2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана. |
| 3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж | <ul style="list-style-type: none">3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө. |
| 4. Худалдан авах ажиллагааны цахим систем | <ul style="list-style-type: none">4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна. |
| 5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх | <ul style="list-style-type: none">5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна. |

**6. Сонирхогч этгээд,
оролцогч**

- 6.1. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.
- 6.2. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.
- 6.3. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.
- 6.4. Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж төлсөн байна.
- 6.5. ТШЗ-ны 6.4-т заасан үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

**7. Түншлэлийн болон
туслан гүйцэтгүүлэх
гэрээ**

- 7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
- 7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.
- 7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
- 7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.
- 7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 7.6. ТШЗ-ны 7.1-д заасан гэрээнд түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэх үүрэг (тоо хэмжээ гэх мэт)-ийг үнийн дүнгийн хамт тодорхойлж, тусгасан байна.

Б.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМ БИЧГИЙН АГУУЛГА

**8. Тендер шалгаруулалтын
баримт бичиг**

- 8.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:
 - I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;
 - II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;
 - III Бүлэг. Техникийн тодорхойлолт
 - IV Бүлэг. Тендерийн жишиг маягт;
 - V Бүлэг. Гэрээний нөхцөл
- 8.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахад тендер

шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

8.3. Худалдан авах барааны онцлогоос хамаарч гэрээний нөхцөлийг V бүлэгт заасан гэрээний нөхцөлөөс өөрөөр тодорхойлох шаардлагатай бол үндэслэлийг дурдаж хуулийн 39.3-т заасанд нийцсэн худалдан авах гэрээний нөхцөлийг баримталж болно.

8.4. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.

9. Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах

9.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүргүүлнэ.

9.2. ТШЗ-ны 9.1-д заасан хүсэлтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.

9.3. Тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэнд тооцно.

10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт

10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах (эсхүл ажлын талбайтай танилцуулах) бол өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2. Уулзалтад ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.

10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

В.ТЕНДЕР БЭЛТГЭХ

11. Тендер шалгаруулалтын баримт бичиг болон тендерийн хэл

11.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг оролцогч бэлтгэн ирүүлнэ.

11.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 11.1-д заасан хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

- 11.3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 11.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална.
- 11.4. Захиалагч ТШЗ-ны 11.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

12. Тендерийн иж бүрдэл

- 12.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн үйлчилгээ үзүүлэх техникийн болон үнийн санал байна.
- 12.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:
- 12.2.1. ТШЗ-ны 13-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;
- 12.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;
- 12.2.3. өгөгдлийн хүснэгтэд зөвшөөрсөн бол ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;
- 12.2.4. ТШЗ-ны 15-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;
- 12.2.5. ТШЗ-ны 17, 18, 19-д заасны дагуу ирүүлсэн баримт бичиг;
- 12.2.6. санал болгож буй үйлчилгээ ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
- 12.2.7. ТШЗ-ны 20.4-т заасан тохиолдолд холбогдох тайлбар;
- 12.2.8. түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.
- 12.2.9. тендер шалгаруулалтын баримт бичигт заасан бусад баримт бичиг.
- 12.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.
- 12.4. Оролцогч хуулийн 22.10-т заасныг үндэслэн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

13. Тендерийн жишиг маягт

- 13.1. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн IV бүлэг дэх жишиг маягтаас аль шаардсан маягтыг дараах байдлаар ирүүлнэ.
- 13.1.1. хуулийн 21.1.3-т заасны дагуу цахим системд үүсгэгдсэн бол цахим системээр ирүүлнэ.

- 13.1.2.ТШЗ-ны 13.1.1-д зааснаас бусад маягтыг тендерт хавсарган ирүүлнэ.
- 14. Хувилбарт санал**
- 14.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж болно.
- 15. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг**
- 15.1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг IV бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.
- 15.2. Хэрэв өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 7.1-д заасан ерөнхий шаардлагыг магадлахтай холбоотой баримт бичгийг ирүүлнэ.
- 15.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:
- 15.3.1.хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;
- 15.3.2.гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;
- 15.3.3.тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох болон ТШЗ-ны 15.2-т заасанд холбогдох баримт бичиг.
- 15.4. Захиалагч оролцогчийн ерөнхий шаардлагыг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 15.2, 15.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.
- 16. Санал болгож буй үйлчилгээ тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг**
- 16.1. Оролцогчийн санал болгож буй үйлчилгээ нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар ирүүлнэ.
- 16.2. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож үйлчилгээний загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилт хийх ажиллагаанд өгөгдлийн хүснэгтэд заасны дагуу оролцоно.
- 16.3. Нотлох баримт нь нийтлэл, зураг төсөл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас зэрэг тухайн гүйцэтгүүлэх ажлын техникийн тодорхойлолттой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг дурдсан баримт байж болно.

- 16.4. III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.
- 16.5. Захиалагчийн гүйцэтгүүлэх үйлчилгээг дагалдах бараа байгаа бол техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримт бичиг ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 16.1-д зааж болно.
- 17. Чадавхын болон туршлагын шаардлага**
- 17.1. Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.
- 17.2. Түншлэл нь ТШЗ-ны 17.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна.
- 17.3. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 17.1-д зааснаар өгөгдлийн хүснэгтэд тусгасан бол түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
- 17.4. Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.
- 17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.
- 17.6. Оролцогч, түүний түншлэлийн гишүүний хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээллийг тендерт ирүүлэхийг шаардах бол өгөгдлийн хүснэгтэд заана.
- 18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**
- 18.1. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 18.2. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

- 18.3. Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 18.1-д заасан тохиолдолд Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
- 19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**
- 19.1. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан болон хуулийн 17.4-т хамаарах баримт бичгийн хүрээнд өгөгдлийн хүснэгтэд заана.
- 20. Тендерийн үнэ**
- 20.1. Хуулийн 34.8-д заасны дагуу үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад оролцогчийн ирүүлсэн эцсийн үнэ түүний тендерийн үнэ байна.
- 20.2. ТШЗ-ны 20.1-д заасан тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 20.3. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
- 20.4. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.
- 21. Тендерийн валют**
- 21.1. Оролцогч Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.
- 21.2. Монгол Улсын олон улсын гэрээнд зааснаар, эсхүл захиалагч Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1-д заасан Монголбанкнаас олгосон зөвшөөрөлд үндэслэн ТШЗ-ны 21.1-д заасан тендерийн валютыг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

- 22. Тендер хүчинтэй байх хугацаа**
- 22.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.
- 22.2. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ, ҮНИЙН САНАЛ ДУУДАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ, ТЕНДЕР НЭЭХ

- 23. Тендер баталгаажуулах, илгээх**
- 23.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар тоон гарын үсгээр баталгаажуулж, цахим системээр илгээнэ.
- 23.2. ТШЗ-ны 23.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.
- 23.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол IV бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 23.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.
- 23.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг IV бүлгийн Маягт 5-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.
- 23.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 23.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.
- 24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**
- 24.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.
- 25. Үнийн санал дуудах ажиллагаа**
- 25.1. Үнийн санал дуудах ажиллагаа хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу явагдана.
- 25.2. Захиалагч хуулийн 34.9-д зааснаар үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад эцсийн үнийг өсөх дарааллаар эрэмбэлж, эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийн тендерийг хянан үзнэ.

- 25.3. Үнийн санал дуудах ажиллагаа эхлэх, үргэлжлэх хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.
26. **Тендер нээх**
- 26.1. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д.ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

27. **Тендер шаардлагад нийцсэн хянан үзэх, үнэлэх**
- 27.1. ТШЗ-ны 25.2-т зааснаар эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн тендерийг хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, Сангийн сайдын баталсан аргачлал, зааврын дагуу ТШЗ-ны 12 дугаар зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ.
- 27.2. Эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн тендер шаардлагад нийцээгүй бол удаах эрэмбэлэгдсэн тендерийг хянан үзнэ.
- 27.3. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
28. **Тендерийн талаар тодруулга авах**
- 28.1. Тендерийг хянан үзэх явцад тодруулга авах шаардлагатай гэж үзвэл хуулийн 25 дугаар зүйлийг баримтална.
29. **Оролцогчийн чадавхыг дахин магадлах**
- 29.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална.
- 29.2. ТШЗ-ны 29.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18-д заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19-д заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
- 29.3. ТШЗ-ны 29.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.
30. **Захиалагч шийдвэр гаргах**
- 30.1. Захиалагч ТШЗ-ны 28, 29, 30-д заасны дагуу оролцогчийн тендерийг хянан үзэж, хуулийн 28.1-д заасан шийдвэрээс аль тохирохыг гаргаж, оролцогч нарт хүргүүлнэ.
31. **Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах**
- 31.1. Захиалагч ТШЗ-ны 8.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
- 31.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 31.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТШЗ-ны холбогдох заалт	А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагчийн нэр: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалтын нэр: Багахангайн үйлдвэрлэл технологийн паркийн хүнд үйлдвэрлэлийн бүсийн хөгжлийн төлөвлөгөө (Улаанбаатар хот) боловсруулах зөвлөх үйлчилгээний ажил
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: НХААГ/ 20250203692
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалтын багцын тоо болон нэр: “Багцгүй”
ТШЗ 1.4	Тендер шалгаруулалтын урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “Үгүй”
ТШЗ 1.5	Үйлчилгээний үр дүнд оюуны өмчийн эрхийг захиалагч, түүний этгээд эзэмших эсэх: “Тийм”
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр: Нийслэлийн төсвийн хөрөнгө
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 90,000,000 төгрөг. (ерэн сая)
Б.АГУУЛГА	
ТШЗ 9.1	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 23 дугаар хороо, Арцатын ам, Нийслэлийн нутгийн захиргааны байр, Б-блок 7 дугаар давхар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Утас: 75757807 www.tender.gov.mn Цахим шуудангийн хаяг: info@procurement.mn, Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр болон тоон гарын үсгээр баталгаажуулан цахимаар захиалагчид гаргаж болно. Захиалагч тодруулга авах хүсэлт хүлээн авснаас хойш тодруулгыг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө бичгээр гаргана. Захиалагч тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг хүсэлт гаргагчийн нэрийг дурдалгүйгээр албан бичгээр гаргаж, түүний хуулбарыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) дэх тендерийн баримт бичгийн “тодруулга” хэсэгт нийтэлнэ. Ийнхүү нийтэлсэн даруйд тус тодруулга, нэмэлт мэдээллийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн салшгүй хэсэг болох тодруулга, нэмэлт, өөрчлөлтийг тендер хүлээж авах эцсийн хугацаа хүртэл шалган нягталж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэнэ.
ТШЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “Үгүй”
В.ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 11.2	Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэлийг ТШЗ 11.1-д зааснаас өөрөөр заах бол: “Үгүй”
ТШЗ 14.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй”

ТШЗ 15.2	Ерөнхий шаардлагыг магадлахтай холбоотой хуулийн 15.2-т зааснаас бусад нотлох баримт ирүүлэх эсэх: Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: “Шаардана” 1.Тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системээс авсан нийгмийн даатгалын шимтгэлийн болон татварын өр төлбөргүй тодорхойлолтыг цахим системийн холбогдох талбараар зааварчилгааны дагуу тус тус ирүүлнэ. Энэхүү тодорхойлолтыг ирүүлээгүй тохиолдолд тендер нээсэн өдрийн байдлаар татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийн талаарх мэдээллийг шалгана. 2.Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр, төлбөргүй талаарх хүчин төгөлдөр лавлагааг цахим системээс авч, зааварчилгааны дагуу цахим системээр холбогдох талбараар ирүүлнэ. 3.Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд “Төрийн мэдээлэл солилцооны ХҮР систем”-ээр дамжуулан шалгана. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) дэх мэдээлэл нь үнэн зөв, бүрэн гүйцэт эсэхийг тендерт оролцогч нь нягтлах үүрэгтэйг анхаарна уу.
ТШЗ 16.1	Техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлоход шаардах баримт бичиг: “Шаардана” -Үйлчилгээ үзүүлэх ажлын хөтөлбөр болон арга, аргачлалын талаарх танилцуулгыг ирүүлнэ. -Үйлчилгээ үзүүлэх хуваарийг техникийн тодорхойлолтын дагуу ирүүлнэ.
ТШЗ 16.2	Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж шаардах эсэх, шалгалт туршилт зохион байгуулах эсэх: “Үгүй”
ТШЗ 17.4	Зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ: “Шаардахгүй”
ТШЗ 17.6	Оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: “Шаардахгүй”
ТШЗ 18.1	Санхүүгийн чадавхын шаардлага: “Шаардана” 1. Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 3 жил буюу 2022, 2023, 2024 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна. 2. Банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өргүй байна. (Хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өргүй гэдгийг нотлохын тулд “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг www.sainscore.mn, www.burenscore.mn хаягаар хандан авна. Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг үнэлэхэд харгалзан үзэхгүй.)
ТШЗ 19.1	Техникийн чадавх болон туршлагын шаардлага: “Шаардана” Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: “Шаардана” -Сүүлийн 3 жил буюу 2022, 2023, 2024 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй хөгжлийн төлөвлөгөө эсхүл түүнтэй адилтгах судалгаа, шинжилгээтэй холбоотой үйлчилгээний гүйцэтгэгчээр доод тал нь нэг удаа ажилласан байх. Ажил гүйцэтгэх хүний нөөц: Шаардана

	Огноо: 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Цаг: 09 цаг 30 минут, 2 цагийн турш үргэлжлэнэ.
ТШЗ 26.1	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Цаг: 09 цаг 30 минут Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо, Арцатын ам, Нийслэлийн Нутгийн захиргааны төв цогцолбор байр Б блок, 7 дугаар давхар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Утас: 75757807
Д.ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ	
ТШЗ 27.3	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: “Үгүй”

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

(Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn ТЭЗҮ хэсгээс
техникийн тодорхойлолттой танилцана уу.)

Үйлчилгээ үзүүлэх хуваарь

№	Нэр төрөл	Үйлчилгээний талаарх тодорхойлолт	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Үйлчилгээ үзүүлэх газар	Үйлчилгээ үзүүлэх хугацаа	
						Үйлчилгээ хүлээн авах хугацаа	Гүйцэтгэгчийн санал болгох хугацаа (оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7	8
1	Багахангайн үйлдвэрлэл технологийн паркийн хүнд үйлдвэрлэлийн бүсийн хөгжлийн төлөвлөгөө (Улаанбаатар хот)	[Үйлчилгээнд холбогдох шинж чанарыг бичих]	[нэгжийн тоо ширхгийг бичих]		Багахангайн үйлдвэрлэл технологийн паркийн хүнд үйлдвэрлэлийн бүсийн хөгжлийн төлөвлөгөө (Улаанбаатар хот)	Гэрээ байгуулснаас хойш хуанлийн 60 хоног (Ажил гүйцэтгэх 60 хоногт магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулах хугацаа ороогүй болно.)	[7 дугаар баганад заасан хугацаанд багтаан гүйцэтгэхээр санал болгож буй хугацааг бичих]
2							
3							
...							

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга/тэмдэг]:

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ

Маягтуудын жагсаалт:

Маягт 1: Тендер илгээх маягт	17
Маягт 2: Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн гэрээний мэдээлэл.....	19
Маягт 3: Хэрэгжүүлж буй, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл	19
Маягт 4: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл	19
Маягт 5: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт	20
Маягт 6: Үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн мэдээлэл.....	20
Маягт 7: Үйлчилгээ үзүүлэх ажилтны товч намтар (CV).....	21

[Захиалагч байгууллагын нэр]

Манай **[оролцогчийн нэр]** нь танай байгууллагаас зарласан **[тендер шалгаруулалтын нэр, дугаар]** тендер шалгаруулалтын үнийн санал дуудах ажиллагаанд эцсийн санал болгосон үнээр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу үйлчилгээ үзүүлэхээр, доор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцохтой холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна. Үүнд:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй;
 - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш **[ажлын 30 ба түүнээс дээш өдрийн тоо бичих]** өдрийн хугацаанд хүчинтэй байна.¹
5. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.
6. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
7. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

¹ Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “4. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.

***[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг,
байгууллагын тамга, тэмдэг]:***

Хаяг:

Маягт 2: Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 3: Хэрэгжүүлж буй, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 4: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Оролцогчийн нэр: *[түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].*

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) ☐ Үндсэн гүйцэтгэгч ☐ Түншлэлийн гишүүн ☐ Туслан гүйцэтгэгч

Маягт 5: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Хүний эмзэг мэдээлэлд хамаарах хууль зүйн үндэслэл, тайлбар
1.		
2.		
...		

Маягт 6: Үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн мэдээлэл

Тухайн үйлчилгээнд санал болгож буй албан тушаал	Ажилтны овог нэр	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Нийт ажлын туршлага, жилээр	Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр

Маягт 7: Үйлчилгээ үзүүлэх ажилтны товч намтар (CV)

Санал болгож буй албан тушаал: _____

Овог, нэр: _____

Мэргэжил: _____

Төрсөн он, сар, өдөр: _____

Тухайн байгууллагад ажилласан жил: _____ Иргэншил: _____

Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: _____

Хариуцах ажил: _____

Ур чадварын:

[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн зөвлөх үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршлыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]

Боловсрол:

[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшсэн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.]

Ажилласан туршлага:

[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]

Хэлний мэдлэг:

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: _____

Огноо: _____

V БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Санамж

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж үйлчилгээ авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), гэрээ баталгаажуулах маягт, түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн үйлчилгээг гүйцэтгүүлэх нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн үйлчилгээг гүйцэтгэхэд хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцох бол түүнийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Гүйцэтгэх үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалт дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг, өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. Зарим жишээ нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ;
7. Гэрээний зүйл болон бусад хэсгийн гарчиг нь гэрээний нөхцөлийн утга агуулгыг тайлбарлах үндэслэл болохгүй.
8. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэрээ байгуулах албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалттай танилцаж, судалсан байх шаардлагатай болохыг анхаарна уу.

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ.ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

1.1.Энэ гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл доор дурдсан утгыг агуулна:

- 1.1.1. “Үйлчилгээ” гэж техникийн тодорхойлолт (үйлчилгээний даалгавар, техникийн тодорхойлолт, гэх мэт)-д заасан үйлчилгээ, болон дагалдах барааг;
- 1.1.2. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
- 1.1.3. “Үйлчилгээ үзүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
- 1.1.4. “Талууд” гэж Захиалагч болон Үйлчилгээ үзүүлэгчийг хамтад нь нэрлэснийг;
- 1.1.5. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
- 1.1.6. “Үйлчилгээ үзүүлэх газар” гэж үйлчилгээг гүйцэтгэх, хүлээлгэн өгөх болон дагалдах бараа нийлүүлэх газрыг;
- 1.1.7. “Доголдол” гэж гүйцэтгэсэн үйлчилгээ, дагалдах барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;
- 1.1.8. “Баталгаат хугацаа” гэж гэрээний дагуу Үйлчилгээ үзүүлэгчийн үзүүлсэн үйлчилгээг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад илэрсэн доголдлыг Үйлчилгээ үзүүлэгч хариуцах хугацааг;
- 1.1.9. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Үйлчилгээ үзүүлэгчид шаардлага гаргах Иргэний хуульд заасан хугацааг;
- 1.1.10. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Үйлчилгээ үзүүлэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
- 1.1.11. “Гүйцэтгэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Үйлчилгээ үзүүлэгчээс томилогдсон этгээдийг;
- 1.1.12. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын

улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Гэрээний тайлбар

- 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
- 1.2.1. ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.
 - 1.2.2. бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.
 - 1.2.3. зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.
 - 1.2.4. ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.
 - 1.2.5. гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

ХОЁР. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ

Үйлчилгээ үзүүлэх

- 2.1. Үйлчилгээ үзүүлэгч нь техникийн тодорхойлолтод заасан үйлчилгээг үйл ажиллагааны хуваарь, ГТН-д заасан хугацаанд гүйцэтгэнэ.
- 2.2. Үйлчилгээ үзүүлэгч гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэх, дагалдах бараа нийлүүлэхэд ажилтан, тоног төхөөрөмж, бараа, материал зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна.
- 2.3. ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.
- 2.4. Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн жишигт нийцүүлэн гүйцэтгэнэ.
- 2.5. Үйлчилгээ үзүүлэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг ханган ажиллана.
- 2.6. Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээг үзүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.

Үйлчилгээ үзүүлэх газар

- 2.7. Үйлчилгээ үзүүлэх, дагалдах бараа нийлүүлэх газрыг ГТН-д заана.

Үйлчилгээ эхлэх хугацаа

- 2.8. Үйлчилгээг ГТН-д заасан хугацаанд эхлүүлнэ.
- 2.9. Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээг ГТН-д заасан хугацаанд Захиалагчид хүлээлгэн өгч акт үйлдэнэ.

Үйлчилгээг хүлээлгэн өгөх хугацаа	2.10. Үйлчилгээ үзүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үйлчилгээ үзүүлэх хугацааг сунгуулах тухай хүсэлт гаргаж болно: 2.10.1. захиалагч ГЕН-ийн 2.6-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй; 2.10.2. үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд үзүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон.
Тайлагнах үүрэг	2.11. Захиалагч ГЕН-ийн 2.10-т заасан нөхцөл бүрдсэн гэж үзвэл Үйлчилгээ үзүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгана. 2.12. ГЕН-ийн 2.10.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Үйлчилгээ үзүүлэгч нотлох үүрэгтэй.
Ажилтныг солих	2.13. Техникийн тодорхойлолтод үе шатны тайланг ирүүлэхээр заасан бол Үйлчилгээ үзүүлэгч нь ГТН-д заасан хугацаанд Захиалагчид хүргүүлнэ.
Барааг хүлээлгэн өгөх	2.14. Ажилтан нас барсан, тэтгэвэрт гарсан, хөдөлмөрийн чадвараа алдсан, гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн болон бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ажиллах боломжгүй болсон тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь тухайн ажилтантай адил, эсхүл илүү чадвар, туршлага бүхий хүнийг нэн даруй авч ажиллуулна. 2.15. ГЕН-ийн 2.14-т зааснаас бусад тохиолдолд ажилтны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахгүй.
Даатгал	2.16. Техникийн тодорхойлолтод зааснаар үйлчилгээг дагалдах бараа нийлүүлэхээр заасан бол Үйлчилгээ үзүүлэгч нь дагалдах барааг ГТН-д заасан нөхцөл, хугацаанд хүлээлгэн өгч, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ. 2.17. Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээ, түүний дагалдах барааг хүлээлгэн өгснөөр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ.
	2.18. Үйлчилгээ үзүүлэгч нь ГТН-д заасан эрсдэлд хамаарах даатгалд өөрийн зардлаар даатгуулж даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчид ирүүлнэ. 2.19. Үйлчилгээ үзүүлэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол Захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Үйлчилгээ үзүүлэгчээс гаргуулна.
ГУРАВ. ЗАХИАЛАГЧ	
Хүлээн авах	3.1 Захиалагч нь үйлчилгээг ГТН-д заасны дагуу хүлээн авч акт үйлдэнэ.
Шалгалт, туршилт	3.2 Үйлчилгээ, дагалдах үйлчилгээ нь тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч, эсхүл түүний төлөөлөгч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч Үйлчилгээ үзүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ. 3.3 Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд үйлчилгээ, дагалдах бараа

доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ.

- | | |
|------------------------------------|---|
| Гэрээний үнэ | 3.4 ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээний доголдлыг арилгана. |
| | 3.5 Үйлчилгээг хүлээн авсан болон шалгалт туршилт хийсэн нь Захиалагчийн доголдолтой холбогдуулж шаардлага гаргах эрхийг хязгаарлахгүй. |
| | 3.6 Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Үйлчилгээ үзүүлэгч хариуцна. |
| | 3.7 Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана. |
| | 3.8 Гэрээний үнэд хуулийн 40.1.2-т заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д заана. |
| Төлбөр төлөх | 3.9 Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Үйлчилгээ үзүүлэгчид төлнө. |
| | 3.10 Үйлчилгээ үзүүлэгчийн хүсэлтээр Захиалагч үүрэг гүйцэтгэх хугацааг ГЕН-ийн 2.11-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ. |
| | 3.11 Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно. |
| | 3.12 Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй. |
| | 3.13 ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална. |
| | 3.14 Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна. |
| | 3.15 Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Үйлчилгээ үзүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана. |
| Өмчлөх эрх | 3.16 Үйлчилгээ үзүүлэгчийн ирүүлсэн бүх төлөвлөгөө, тайлан, болон бусад баримт бичиг нь Захиалагчийн өмч байна. Үйлчилгээ үзүүлэгч нь эдгээр баримт бичгийн хуулбарыг авч үлдэж болох бөгөөд энэ тохиолдолд ГТН-д заасан хязгаарлалтын хүрээнд ашиглаж болно. |
| | 3.17 Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 1.5-д заасан этгээдэд үйлчилгээний үр дүнд бий болох оюуны өмчийн эзэмших эрх хадгалагдана. |
| ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА | |
| Баталгаат хугацаа | 4.1. Баталгаат хугацааг ГТН-д заана. |
| | 4.2. Баталгаат хугацааг ГТН-д заасан бол энэ хугацааны дотор, баталгаат хугацаа заагаагүй бол үйлчилгээг хүлээн авснаас хойш Иргэний хуульд заасан хугацаанд Захиалагч гомдлын шаардлага гаргаж болно. |
| | 4.3. Захиалагч нь баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаанд илэрсэн доголдолтой үйлчилгээний доголдлыг арилгахыг шаардах эрхтэй. |

Доголдлыг илрүүлэх, арилгах	4.4.	Захиалагч үйлчилгээний гүйцэтгэлийг шалгаж илэрсэн доголдлын талаар Үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэнэ.
	4.5.	Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор, шалгалт, туршилт хийж болно.
	4.6.	Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа, эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлнэ.
	4.7.	Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Үйлчилгээ үзүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.
	4.8.	Үйлчилгээ үзүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно.
	4.9.	Захиалагчийн гаргасан зардлыг Үйлчилгээ үзүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.
	4.10.	Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг үйлчилгээ үзүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.
	4.11.	Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Үйлчилгээ үзүүлэгчид төлнө.
	4.12.	Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээг ГТН-д заасан хугацаанд үзүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.
	4.13.	Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүсэж үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүй болсон бол Үйлчилгээ үзүүлэгч нь энэ тухай Захиалагчид ердийн боломжит хугацаанд бичгээр мэдэгдэнэ.
Алданги	4.14.	Үйлчилгээ үзүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.
	4.15.	Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.
	4.16.	Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Үйлчилгээ үзүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч ГЕН-ийн 2.10-т заасан хүсэлт гаргаж болно.
	4.17.	Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.
Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал	4.18.	Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.
Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа		

ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл	5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээг цуцлах эрхтэй: 5.1.1. Үйлчилгээ үзүүлэгч нь ГЕН-ийн дагуу мэдэгдэл хүлээн авч тогтоосон хугацаанд доголдлыг арилгаагүй; 5.1.2. Үйлчилгээ үзүүлэгчийн төлөх алдангийн хэмжээ гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин хувь)-д хүрсэн; 5.1.3. Үйлчилгээ үзүүлэгч тендерт оролцох, бараа нийлүүлэх явцад авлигын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон. 5.1.4. Үйлчилгээ үзүүлэх хугацаанд Үйлчилгээ үзүүлэгчийн зөвшөөрөл, гэрчилгээний хугацаа дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон; 5.1.5. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн; 5.1.6. Үйлчилгээ үзүүлэгч нь ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн; 5.1.7. Үйлчилгээ үзүүлэгч гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн.
Үйлчилгээ үзүүлэгч гэрээг цуцлах	5.2. Үйлчилгээ үзүүлэгч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээг цуцлах эрхтэй: 5.2.1. Захиалагч нь ГТН-д заасан хугацаанд төлбөр төлөөгүй; 5.2.2. Төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөр төлөөгүй; 5.2.3. Захиалагчийн төлөх алдангийн хэмжээ гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин хувь)-д хүрсэн. 5.3. Үйлчилгээ үзүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.
Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэл	5.4. ГЕН-ийн 5.1, 5.2-т заасан гэрээ цуцлах үндэслэл бүрдсэн тохиолдолд гэрээ цуцлах мэдэгдлийг нөгөө талд бичгээр өгнө. 5.5. Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна. 5.6. Гэрээ цуцлагдсан тохиолдолд нөгөө талд учирсан хохирлыг үүрэг зөрчсөн тал Иргэний хуульд заасан журмын дагуу арилгана.
Төлөөлөгч	ЗУРГАА. БУСАД НӨХЦӨЛ 6.1. Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.

	6.2.	Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.
	6.3.	Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.
	6.4.	Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
Туслан гүйцэтгэгч	6.5.	Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгчийн ирүүлсэн тендерт зааснаас илүү хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй. Тендерт санал болгосноор туслан гүйцэтгэгчийг оролцуулах ба өөрчлөлт орох зайлшгүй шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авах бөгөөд өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3 дахь заалт хангагдсан байна.
	6.6.	Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтрүүлэх, ажлын доголдол гэх мэт) Үйлчилгээ үзүүлэгч хариуцна.
Оюуны өмч	6.7.	Үйлчилгээг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
Нууцлал	6.8.	Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.
	6.9.	Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.
Мэдэгдэл	6.10.	Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.
	6.11.	Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.10-т зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.
	6.12.	Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх, эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.
	6.13.	Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:
	6.13.1.	баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн;

	6.13.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.
	6.14. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
	6.15. ГЕН-ийн 6.14-т заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.
Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах	6.16. Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна: 6.16.1. ГЕН-ийн 2.11-д заасны дагуу хугацаа сунгагдсан; 6.16.2. үнийн тохируулга хийсэн.
	6.17. Гэрээний нэмэлт, өөрчлөлтөд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
	6.18. ГЕН-ийн 6.16-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.
Маргаан шийдвэрлэх	6.19. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
	6.20. Талууд зөвшилцөж шийдвэрлэж эс чадвал Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
Бусад	6.21. Гэрээний хүчинтэй байх хугацаанд үйлчилгээ үзүүлэгчийн зөвшөөрөл, эсхүл гэрчилгээний хүчинтэй байх хугацаа дуусгавар болох нөхцөл бий болсон бол хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө энэ талаар Захиалагчид мэдэгдэж, гэрээний үүргийг зөвшөөрөл, гэрчилгээний хугацаа сунгасан шийдвэр гарах хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх шийдвэрийг Захиалагч гаргаж болно.
	6.22. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэрээ байгуулах албан тушаалтан энэ хуульд зааснаар нийтийн албан тушаалтны ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарыг бөглөсөн байна.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.1.	Үйлчилгээ үзүүлэх хугацаа: Гэрээ байгуулснаас хойш хуанлийн 60 хоног (Ажил гүйцэтгэх 60 хоногт магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулах хугацаа ороогүй болно.)
ГЕН 2.7.	Үйлчилгээ үзүүлэх, дагалдах бараа нийлүүлэх газар: Хот байгуулалт, хотын стандартын газар.
ГЕН 2.8.	Үйлчилгээ үзүүлж эхлэх хугацаа: Гэрээ байгуулсан өдрөөс хойш
ГЕН 2.9.	Ажил үйлчилгээг хүлээлгэн өгөх: Үйлчилгээг хүлээлгэн өгөх хугацаа: Гэрээ байгуулснаас хойш хуанлийн 60 хоног (Ажил гүйцэтгэх 60 хоногт магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулах хугацаа ороогүй болно.)
ГЕН 2.13.	Үе шатны тайлан ирүүлэхээр тендер шалгаруулалтын баримт бичгийн техникийн тодорхойлолтод заасан эсэх: “Тийм” (Техникийн тодорхойлолтод тусгасны дагуу)
ГЕН 2.16.	Үйлчилгээг дагалдах бараа байгаа эсэх: “Үгүй”
ГЕН 2.18.	Даатгал: Гүйцэтгэгч өөрөө хариуцна.
ГЕН 3.1.	Үйлчилгээг хүлээн авах нөхцөл, журам:
ГЕН 3.8.	Үнийн тохируулга: “Хийхгүй”
ГЕН 3.9.	Төлбөр төлөх хугацаа: Гүйцэтгэлээр санхүүжнэ.
ГЕН 3.16.	Баримт бичиг ашиглах хүрээ:
ГЕН 4.1.	Баталгаат хугацаа: 1 жил
ГЕН 4.11.	Захиалагчийн төлөх алдангийн хувь: Алдангийн хувь: “Үгүй”
ГЕН 4.12.	Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь: Алдангийн хувь: Алдангийн хувь: Алданги ногдуулах хэмжээ хоногт гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,05 хувьтай тэнцүү байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй дүнтэй байна.

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.

Дугаар № **[Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]**

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэрийг бичих]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[үйлчилгээ үзүүлэгчийн нэрийг бичих]** (цаашид “гүйцэтгэгч” гэх) нь ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэ гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Үйлчилгээ” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Үйлчилгээний үнэ нь **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч **[Гүйцэтгэгчийн нэрийг бичих]**-ийн харилцах **[Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.
3. Доор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 1.1. Гүйцэтгэгчийн тендер, холбогдох маягт;
 - 3.2. Гэрээний тусгай нөхцөл;
 - 3.3. Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 3.4. Техникийн тодорхойлолт;
 - 3.5. Үйлчилгээ үзүүлэх хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:

4.1. Захиалагчийн мэдээлэл:	төлөөлөгчийн	4.2. Гүйцэтгэгчийн мэдээлэл:	төлөөлөгчийн
Эцэг/эх-ийн нэр:		Эцэг/эх-ийн нэр:	
Нэр:		Нэр:	
Албан тушаал:		Албан тушаал:	
Ажлын утас:		Ажлын утас:	
Гар утас:		Гар утас:	
Цахим шуудан:		Цахим шуудан:	

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: 2025 оны 10 дугаар сарын 23
Тендер шалгаруулалтын төрөл: Үйлчилгээ
Тендер шалгаруулалтын нэр: Багахангайн үйлдвэрлэл технологийн
паркийн хүнд үйлдвэрлэлийн бүсийн
хөгжлийн төлөвлөгөө (Улаанбаатар хот)
Тендер шалгаруулалтын дугаар: НХААГ/ 20250203692
Нийт төсөвт өртөг: 90,000,000 төгрөг (ерэн сая)
Тендер шалгаруулалтын арга: **Харьцуулалт**

1. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: “Багцгүй”
3. Үнийн санал дуудах ажиллагаанд шаардлагатай оролцогчийн тоо: 1-ээс доошгүй
4. Үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлэх журам:
5. Үнийн санал дуудах ажиллагааг 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 09 цаг 30 минутад эхлүүлж, 02 цаг 10 минутын хугацаанд зохион байгуулна.
6. Тендерийг 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн, 09 цаг 00 минутаас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн, 09 цаг 30 минутад нээнэ.
7. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: “Зөвшөөрөхгүй”
8. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: Эрхгүй
9. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
10. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг доорх хаягаар хүргүүлж болно.

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо, Арцатын ам,
Нийслэлийн Нутгийн захиргааны төв цогцолбор байр Б блок, 7 дугаар давхар,
Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар,
Утас: 75757810

www.tender.gov.mn, www.ub-procurement.mn